



ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/39

Батширээт сум

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх,  
тэмцэх, шуурхай бүлэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, "Ойн тухай хууль"-ийн 18 дугаар зүйлийн 18.2.13, 18.2.18 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх шуурхай бүлгийн 1, 2, 3-р ээлжинд ажиллах хүмүүсийн нэрсийг хавсралтаар баталсугай.
2. Шуурхай бүлгийн бие бүрэлдэхүүнийг түймрийн аюултай үе болох 2025 оны 03 дугаар сарын 15-наас 06 дугаар сарын 10, 09 дүгээр сарын 15-наас 11 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд багаж тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангаж, байнгын бэлэн байдалд ажиллахыг ээлжийн ахлагч (Б.Мөнх-Очир)-т хариуцуулсугай.
3. Шуурхай бүлгийг холбогдох сургалт дадлагад хамруулан, аюулгүй ажиллагааны талаар заавар зөвлөгөө өгч, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Бүдханд)-д үүрэг болгосугай.
4. Гамшгийн үед дуут дохио болон зарлан мэдээллийн дагуу хугацаа хожимдохгүй бэлэн цуглаж байхыг шуурхай бүлгийн нийт бие бүрэлдэхүүнд анхааруулсугай.
5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Төрмөнх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ

23250107